



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/7226

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай" 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, нийт 40,896,938.25 (дөчин сая найман зуун ерэн зургаан мянга есөн зуун гучин найман төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 18,403,622.22 (арван найман сая дөрвөн зуун гурван мянга зургаан зуун хорин хоёр төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан тус дүүргийн 1 дүгээр хорооны соёлын төвийн ашиглалтгүй барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (Г.Бат-Очир)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 5,879,000.00 (таван сая найман зуун далан есөн мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (Г.Бат-Очир), орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205360



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 21 өдрийн
А.Т.А. 26 дугаар захирамжийн
хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Налайх дүүргийн 1 дүгээр хорооны соёлын төвийн ашиглалтгүй барилга	1978	Налайх дүүрэг 1 дүгээр хороо	40,896,938.25	22,493,316.03	18,403,622.22	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагчийн 2024 оны 02-13-01/027/42 дугаар дүгнэлт
Нийт дүн							